

Р.Балжир “Авто замын барилга, шинэчлэлт, засварын ажлын талбайн хяналтын зохион байгуулалт” (Хоёрдугаар хэвлэл)

А. “Зам, замын байгууламжийн барилга угсралтын ажлын хяналтын зөвлөх үйлчилгээний гарын авлага” (Анхдугаар хэвлэл)

2015 онд хэвлэгдэн уг ном нь *Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулагдсан, бэлтгэл нь бүрэн хангагдаж, улмаар зохион байгуулалт нь аль хэдийнээ хийгдэж, талбайд ажлаа эхлэхэд бэлэн болсон хяналтын багийн дотоод ажилд болон түүний гишүүдийн практик үйл ажиллагаанд* зориулагдсан, бүр тодруулвал, аливаа объектын талбайн хяналтад томилогдон гарсан хүмүүс ажлаа гүйцэхдээ юунд анхаарч, ямар байдлаар ажиллах талаарх арга ажиллагааг заасан, талбайн хяналтын үйл ажиллагааны зарим нэг онцлог бөгөөд нарийн ширийн зүйлийг холбогдох хүмүүс нь тунгаан ойлгож, тусган авч, цаашид баримталж ажиллахад чиг баримжаа өгөх зорилгоор бичигдсэн тул түүнийг авто замын арчлалт, засварын ажлын талбайн хяналтад мөн адил хэрэглэх бүрэн боломжтой. Гэхдээ эдгээр ажлын талбайд хийгдэх хяналт, хэмжилт, туршилт ба баталгаажуулалтын үйл ажиллагааны зарим зүйлсийг хэрэглэгчдийн аюулгүй байдал, ая тух, цаашлаад тухайн ажлын технологи, аргачлал, цаг хугацааны хүчин зүйл, байгаль, цаг уурын нөхцөл, хөдөлгөөний зохион байгуулалт зэрэгтэй нягт уялдуулан хэрэглэх шаардлагатайг сайтар анхаарах нь зүйтэй.

Б. “Авто замын барилга, шинэчлэлт, засварын ажлын талбайн хяналтын зохион байгуулалт” (Хоёрдугаар хэвлэл)

Харин анхны номонд огт хөндөгдөлгүй орхигдсон, замын барилга, шинэчлэлт, засварын ажлын талбайн хяналтын нийт үйл ажиллагааны нөгөө нэг чухал хэсэг нь болох ерөнхий зохион байгуулалтын холбогдолтой асуудлуудыг, мөн ерөнхий зохион байгуулалтыг хэрхэн хийх талаар 2022 онд хэвлэгдэн гарсан энэ номонд чухам яг энэ талаас нь тусгасан бөгөөд энэ нь авто замын арчлалт ба урсгал засварт мөн хамаарна.

Үүнтэй холбогдолтой тухайн номын зарим хэсгийг доор оруулав.

1 дүгээр бүлэг. ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Авто зам, гүүр, аэродромын ямар нэгэн объектын барилга, шинэчлэлт ба засварын төсөл нь сүлжээний болон эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөөнд нарийвчилсан байдлаар тусгагдах цаг мөчөөс түүнийг бүрэн дуусгаж, ашиглалтад оруулах хүртэлх урт хугацаанд тодорхой дэс дараалал ба үе шаттайгаар явагддаг Зөвлөхийн сонгон шалгаруулалт, урьдчилсан судалгаа болон ТЭЗҮ, инженерийн зураг болон бусад баримт бичгийн боловсруулалт, Гүйцэтгэгчийн тендерийн үйл ажиллагаа, барилгын ажлууд, талбайн хяналт зэрэг хоорондоо нягт харилцан уялдаатай олон төрлийн ажлыг хамардаг билээ. Эдгээрийг өөр өөрийн чиглэлээр хариуцсан Захиалагч, Гүйцэтгэгч ба Зөвлөх нар хир зэрэг хийж гүйцэтгэхээс төсөл, арга хэмжээний эцсийн үр дүн бүрэн шалтгаалдаг учиртай.

Эдгээр байгууллагуудын хувьд ЗҮ-тэй бүхэлд нь холбоотой ямар асуудлууд байдаг, энэ чиглэлээр ямар ажлуудыг хийх, мөн тэдгээрийг хэдийд, хэрхэн гүйцэтгэх шаардлагатай зэргийг нарийн сайн мэддэг байхын чухлыг бас онцлох нь зүйтэй.

1.1 ТАЛБАЙН ХЯНАЛТЫН ТУХАЙ

Авто замын аливаа барилга, байгууламжийн талбай дээр явагдаж байгаа бүх ажлын ерөнхий удирдамж чиглэл, зөвөлгөө, зааварчилгаа, хоорондын уялдуулалт, зохицуулалт, чанарын хяналт ба түүний баталгаажуулалтыг иж бүрнээр нь **талбайн хяналт** гэж нэрлэнэ. Өнөөгийн мөрдөж буй “Авто замын тухай хууль”-д талбайн хяналтын зөвхөн нэг хэсгийг нь салгаж авч *техник, технологийн хяналт* гэсэн нэрээр, хяналтыг бүхэлд нь төлөөлүүлэн тусгасан нь буруу бөгөөд үүнээс үүдэлтэй алдаа дутагдлын тоймыг номын өмнөх үгээс харж болно.

Авто замыг шинээр барих, шинэчлэх, засварлах ажлын хувьд тодруулвал талбайн хяналт гэдэг нь эдгээр (шаардлагатай бүх төрлийн материал, хийц, бүтээгдэхүүнийг олборлох, үйлдвэрлэх, ашиглахтай холбогдсон асуудлууд бүхэлдээ хамрагдсан) ажлыг гүйцэтгэх явцад Гэрээний баримт бичгүүдийн нөхцөл, зүйл заалтын, ялангуяа чанарын шаардлагын биелэлт ба хангалтыг шалгаж, баталгаажуулах цогц үйл ажиллагаа юм.

Цогц гэдэг нь талбайн хяналтын доор жагсаасан бүрдэл хэсгүүд нь замын барилга, шинэчлэлт ба засварын ажлын бүх үе шатанд иж бүрнээрээ, жигд ба тасралтгүй явагдана гэсэн үг гэж ойлгох хэрэгтэй. Тэдгээрт:

- ✓ Гэрээний мөрдөлтийн,
- ✓ Чанарын удирдлагын,
- ✓ Арга ажиллагааны ба технологийн,
- ✓ Эрүүл мэнд ба аюулгүй байдлын,
- ✓ Байгаль орчны хамгааллын,
- ✓ Зохион байгуулалтын хяналт багтана.

Ер нь талбайн хяналтыг удирдлагын ба гүйцэтгэлийн аль ч шатанд зөвхөн Зөвлөхийн (хяналтын байгууллагын) хийдэг ажил мэтээр ойлгодог байдал авто замын ихэнх ажилд, ялангуяа дотоодын хөрөнгө оруулалттай барилга, засварын ажлууд дээр нилээд түгээмэл явж ирсэн бөгөөд ийм ч учраас Захилагч болон Гүйцэтгэгчийн энэ талын үүрэг ба хариуцлага бараг хөндөгдөхгүй орхигдсоор байгаа билээ. Энэ бол маш буруу хандлага бөгөөд Талууд үүнээс нэн даруй ангижирч, зөв гольдролд нь оруулж залруулах шаардлагатай туйлын чухал асуудал болоод байна.

Үүнтэй зайлшгүй холбож авч үзэх шаардлагатай бөгөөд өнөөгийн байдлаар ихээхэн учир дутагдалтай байгаа нэг асуудал бол талбайн хяналтыг маш явцуу хүрээгээр харж, дутуу ойлгодог, мөн одоо мөрдөж буй хуулинд буруу бөгөөд оновчгүй нэр томъёогоор тусгасан зэргээс зам, гүүрийн барилга, шинэчлэлт, засварын ажлын талбайд иж бүрнээрээ хийгдвэл зохих дээр дурдсан олон талт хяналтын зарим төрлүүд бүрмөсөн орхигдсон явдал юм.

Энэхүү гарын авлагад хөндсөн асуудлууд нь өнгөц харахад голчлон хяналтын байгууллагын буюу Зөвлөхийн ажилтай холбогдолтой мэт боловч цаагуураа бол тийм биш юм. Учир нь замын барилга, шинэчлэлт, их засварын аливаа төслийг хэрэгжүүлэхэд байнгын оролцогч гурван талын 2 гол тоглогч нь Захиалагч, Гүйцэтгэгч нар бөгөөд Барилгын ажлын гэрээний биелэлт нь эдгээр байгууллагуудын үйл ажиллагаатай маш нягт холбоотой байдаг учраас энд тусгасан асуудлууд мөн шууд ба шууд бус утгаараа тэдэнд болоод тэдний ИТАжилтануудад

нэгэн адил хамааралтай гэдгийг үл мартан, энэхүү гарын авлагыг ашиглахыг зөвлөж байна.

1.2 ТАЛБАЙН ХЯНАЛТЫН ЗОРИЛГО

Авто зам, замын байгууламжийн барилга, шинэчлэлт, их засварын бүх төрлийн үе шатны ажлууд нь Гэрээг бүрдүүлдэг баримт бичгүүдийн дагуу хийгдэж байгаа эсэхийг нэг талаас *тогтоож нотлоход ба* нөгөө талаас *түүний үр дүнг шалгаж, баталгаажуулахад талбайн хяналтын зорилго* оршдог.

Ер нь талбайн хяналтын бүхий л үйл ажиллагаа нь ФИДИК-ийн “Барилгын ажлын гэрээ” (БАГ)-ний ерөнхий нөхцөл (ЕН) буюу (цаашид **Улаан ном** гэх) ба Захиалагч ба Зөвлөхийн хооронд байгуулах “Зөвлөх үйлчилгээний гэрээ” (ЗҮГ)-ний ерөнхий нөхцөл (цаашид **Цагаан ном** гэх)-ийн дагуу явагддаг бөгөөд Захиалагч, Гүйцэтгэгч ба Зөвлөх нь тэдгээрийн холбогдох зүйл, заалт бүрийг ягштал баримтлан, тус тусын холбогдох үүргийг зохих журмаар нь биелүүлж, дээрх зорилгыг бүрэн хангаж ажиллах ёстой юм.

Гэрээний иж бүрдэлд ордог баримт бичгүүд болон тэдгээрийн давуу байдлын эрэмбийн талаар Улаан номын Дэд зүйл 1.5 ба Цагаан номын дэд зүйл 1.15-аас тус тус үзэж, судлаарай. Мөн Цагаан номын нэршлийн талаарх тайлбарыг доор 1.16-аас үзнэ үү.

1.3 ТАЛБАЙН ХЯНАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ

Авто зам, замын байгууламжийн барилга, шинэчлэлт, их засварын бүх төрлийн ажлын хяналтын үйл ажиллагааг хир зэрэг зөв зохион байгуулсанаас тухайн ажлын явц, чанар чансаа, өртөг зардал, хугацаа зэрэг гол үзүүлэлтүүдийн хангалт, эцсийн үр дүн, цаашдын бүх хувь заяа бүрмөсөн шалтгаалдаг.

Буруу зохион байгуулалт, аргачлал, дэс дарааллаар, оновчгүй хэлбэр ба бүтцээр, дээр нь зохих дадлага туршлагагүй удирдлагатайгаар эхлүүлсэн хяналт нь авто зам, замын байгууламжийн үе шатны болон хийц хэсгүүдийн түвшин, байршлын алдаа мэдгийг хараанаасаа гаргах, технологийн болоод цаг хугацааны нарийн уялдаатай ажлуудыг хойно, урд нь оруулан буруу зөрүү хийлгэх, хийх ёстой ажлыг орхигдуулах, эсхүл шаардлагагүй зүйлсийг нэмж хийлгэх, үүнээс шалтгаалан ажлын тоо хэмжээнд ихээхэн өөрчлөлт орох зэргээр талбайн ажлыг хөл толгой нь мэдэгдэхгүй эмх замбраагүй байдалд оруулдаг бөгөөд эдгээр нь цаашдаа Гүйцэтгэгч зүй бус алдагдалд орох, хамгийн ноцтой нь барилгын төлөвлөсөн хугацаа сунаж уртсах, ингэснээрээ өртөг зардал нэмэгдэхэд хүргэдэг маш хортой асуудал болж хувирдаг.

Ийм учраас төсөлд оролцогч бүх Талууд үүнд онцгой ач холбогдол өгч, талбайн хяналтыг бүр эхнээс нь туйлын хариуцлагатайгаар, тун хянамгай байдлаар, зөв зохион байгуулж, зөв гүйцэтгэх нь хамгийн чухал юм. Ингэж чадсан тохиолдолд бүх ажил маш ойлгомжтой, элдэв зөрчил, маргаангүйгээр, хөнгөн шуурхай, сааталгүй жигд, үр бүтээлтэй, урамтай сайхан явагддаг болохыг хэн бүхэн мэдрэх болно.

1.4 ТАЛБАЙН ХЯНАЛТЫН ОНЦЛОГ НӨХЦЛҮҮД

Талбайн хяналт нь эрх зүй, ур чадвар, цаг хугацааны холбогдолтой доор дурдсан онцлог нөхцлүүд хангагдсан тохиолдолд л чанартай бөгөөд иж бүрэн хийгддэг зүй тогтолтой тул хөндлөнгийн хяналт бүхий аливаа төсөлд оролцогч

Талууд тус тусын үйл ажиллагааг явуулахдаа тэдгээрийг заавал хангаж байх шаардлагатай.

1.4.1 Хяналтын эрхийг бүрэн шилжүүлж өгсөн байх

Талбайн хяналт үр дүнтэй байх гол нөхцөл нь бүх асуудлыг Захиалагчийн нэрийн өмнөөс шуурхай шийдвэрлэн ажиллахад шаардлагатай, Гэрээний нөхцөлд заасан холбогдох эрх мэдлийг түүнээс Инженерт, цаг тухайд нь, бүрэн шилжүүлж өгсөн байх явдал юм.

Талуудын эрх, үүрэг ба хариуцлагын тэнцвэртэй байдлыг бүрэн хангахад, улмаар зохих хариуцлагыг Гэрээний холбогдох заалтын дагуу тооцоход энэхүү эрх шилжүүлэх асуудал онцгой үүрэг гүйцэтгэдэг тул элдэв шалтаг шалтгаанаар үүнээс бултах, зайлсхийх нь эргээд тодорхойгүй, эсвэл маргаантай асуудал үүсгэх ноцтой үр дагавартайг байнга санаж байх хэрэгтэй.

1.4.2 Хяналтыг чадварлаг бөгөөд шаардлагын хэмжээнд гүйцэтгэх

Зөвлөх нь талбайн хяналтыг өндөр ёс зүйтэй, сахилга баттай, үүрэг, хариуцлагын хуваарилалт ба ажлын дэс дарааллыг хатуу мөрддөг, нийт ажлын арга технологийн мэдлэг, туршлагыг сайн эзэмшсэн, тухайн объектын цар хэмжээ, онцлог, төвөгшлийг сайтар судалж мэдсэн ур чадвар, туршлага сайтай мэргэжлийн ажилтнуудаас бүрдсэн багаар Гэрээний заалт ба бусад холбогдох шаардлагыг бүрэн хангасан хэмжээнд, чадварлаг гүйцэтгэх ёстой.

Ингэж ажиллахад Зөвлөхөөс өөрөөс нь маш их юм шалтгаалдагийг сайтар ухамсарлаж, тендерт бэлтгэн үнийн саналаа боловсруулж эхлэх мөчөөс (урьд нь буруу хөрвүүлж, түүгээрээ нэрлэж заншсан баталгаат засварын) буюу одоо Улаан номонд тодорхойлсоны дагуу шинээр мөрдөх “Эвдрэлийг мэдэгдэх хугацаа” (ЭМХ) дуусах хүртэл үргэлжлэх томоохон орон зайнд үндсэн ажил, үүргийн бодит шаардлагаар зайлшгүй нүүр тулан, зохицуулах ба шийдвэрлэх ёстой олон хүчин зүйлийг тун чамбай тооцон, хүн хүч, өртөг зардлаас өгсүүлээд бүх ажлаа нарийн төлөвлөх хэрэгтэй.

1.4.3 Хяналт цаг хугацаандаа хийгдэх

Хяналтын бүх ажлууд нь Гүйцэтгэгчээс ажил шалгуулах хүсэлт (АШХ)-дээ заасан, эсвэл Гэрээний холбогдох баримт бичгүүдэд тогтоосон хугацаанд, бүрэн хийгдсэн байх ёстой тул Зөвлөх нь өөрийн ажлаа цаг хугацааны тодорхой хуваарьтайгаар, тухай бүрд нь нарийн зохицуулж, сайтар зохион байгуулж ажиллах хэрэгтэй.

Ухаалаг техник, технологийн өндөр хөгжил дэвшлийн үр өгөөж манай салбарт нэвтэрч эхлэх төдий байгаа өнөөгийн нөхцөлд энэхүү зорилтыг хангахын тулд хяналтын холбогдох бүх хүмүүс нь ажлын талбайд биечлэн ажиллах гарцаагүй шаардлагатай юм. Хяналтын ажилтнууд нь талбай руу аль болохоор тогтмол явж, тус тусын чиглэлээрээ хаана нь ямар ажил хэрхэн явагдаж байгааг, ямар хүмүүс яаж ажиллаж байгааг тодорхой хугацаанд шалгаж, мэдэж байх хэрэгтэй, энэ нь газар дээрх алдаа дутагдлыг олж илрүүлэх, зохих хүмүүст нь хэлж анхааруулах, цаг тухайд нь засварлуулах, арилгуулахад тустай байдаг юм.

Нөгөө талаас талбайн хяналт цаг хугацаандаа хийгдэх, эсэх нь ихэнхдээ Гүйцэтгэгчийн ажлын төлөвлөгөө ба гүйцэтгэлээс шууд хамаардаг тул тэрээр бүх ажлаа мөн зохих шаардлагын хэмжээнд зохион байгуулж явуулах ёстой болно.

Ер нь энэ асуудал нь үндсэндээ Зөвлөхийн ажил, үүргийн тодорхой хэсгийг эзэлдэг учир үүнийг тэрээр оновчтой байдлаар хянаж зохицуулан, Талуудын ажлын нягт уялдааг хангуулах ёстой.

1.4.4 Хяналт тогтмол баталгаажих байх

Талбайн хяналтын үр дүн нь өдөр тутмын тэмдэглэл, талбайн зааварчилгаа, өгсөн зөвшөөрөл болон тэдгээрт хавсаргасан дагалдах материалууд, төрөл бүрийн хүснэгт, жагсаалт ба холбогдох бусад баримт бичгүүдийг хамруулсан тодорхой бүртгэл, тайлангаар тогтмол баталгаажих байх ёстой. Энэхүү баталгаажуулт нь Гүйцэтгэгч ба Зөвлөхөөс тус тусын гэрээний үүргээ хир зэрэг хариуцлагатай, мөн чанартай биелүүлж, хэрхэн оролцож байгаагаас ихээхэн шалтгаалдагийг Талууд байнга санаж, элдэв хийдэл, алдаа мадаг гаргалгүй ажиллах хэрэгтэй. Нөгөө талаас, тогтоосон цагтаа хийгдсэн баталгаажуулалт нь Гүйцэтгэгчийн ажлыг хурдан шуурхай явуулах, улмаар цаашдын ажилд саатал гаргуулахгүй байх, гүйцэтгэсэн ажлын төлбөрийг зохих хугацаанд нь, бүрэн авах боломж олгодог маш чухал зүйл юм гэдгийг компаниуд сайтар ойлгож, зөв хандах нь зүйтэй юм.

Талбайд хийгдсэн ажлын чанарын хяналтын үр дүнг баталгаажуулах үйл ажиллагаанд тухайн нэр төрлийн ажилтай холбоотой Зөвлөхийн ИТА-ууд биечлэн оролцож, тус тусын ажил үүргийн хуваарьт заасны дагуу зохих үнэлгээ болон дүгнэлтийг өгөх ба эцсийн шийдвэрийг Төлөөний Инженер (ТИ) гаргадаг.

Баталгаажуулалтад хэрэглэдэг маягтыг {Ажил шалгуулах хүсэлт (АШХ)/Дараачийн ажлын зөвшөөрөл} Зөвлөх үйлчилгээний гарын авлага (анхдугаар хэвлэл буюу Ногоон ном)-оос, мөн энэ номын Хавсралт В-ээс үзэж, мөн авч ашиглаарай.

1.5 ТАЛБАЙН ХЯНАЛТЫГ ГҮЙЦЭТГЭХЭД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Талбайн хяналт нь:

- Зөв дарааллаар,
- Гүйцэтгэгч ба Зөвлөхийн харилцан итгэлцэл дээр тулгуурласан байдлаар,
- Тогтоосон хэмжээ ба давтамжаар тогтмол

гэсэн 3 зарчмаар хийгддэг байх ёстой.

1.5.1 Талбайн хяналтын зөв дараалал

Ер нь аливаа объектын *чанарын асуудал* нь дэлхий нийтэд мөрддөг зарчмаар *зөвхөн Гүйцэтгэгчийн*, өөр хэнтэй ч хуваалцдаггүй *үүрэг* байдаг. Ийм учраас талбайд ашиглаж буй материал хийц, хийгдэж байгаа барилга угсралтын бүх ажлын үе шатны чанарын хяналт, шалгалтыг **эхлээд Гүйцэтгэгч өөрөө** бүрэн хийнэ. Үүний тулд тэр нь хийж байгаа ажлаа Гэрээний холбогдох баримт бичгүүдийн шаардлагад нийцэж байгааг нотлон харуулах өөрийн Чанарын удирдлагын тогтолцоо (ЧУТ)-г тусгайлан боловсруулж, чанд мөрдөж ажиллах ёстой. Энэхүү тогтолцоог ямар бүтэц, агуулгатайгаар хэрхэн боловсруулах, Инженерт хэдийд танилцуулж хянуулах, үүндээ дотоод аудитыг ямар хугацаанд, хэдэн удаа хийж байх, аудитын тайлангаа хэзээ танилцуулах талаар Улаан номын Дэд зүйл 4.9-д нарийвчилсан заасан байдгийг сануулая.

Нөгөө талаас, авто зам, замын байгууламжийн барилга, шинэчлэлт ба засварын бүх үе шатны ажил Гэрээний баримт бичгийн дагуу, чанарын зохих үзүүлэлттэй хийгдэхэд, тэнд хяналт гүйцэтгэх Зөвлөхийн үйл ажиллагаа ямар байх нь бас нэг үндсэн нөхцөл болдог бөгөөд тухайн объектын чанарт үлэмж нөлөөлдөг

чухал хүчин зүйл юм. Ийм учраас талбайд хийж дууссан ажлаа Гүйцэтгэгч шалгаж, нотолсон үр дүнгээ танилцуулсаны **дараа**, тэдгээрийг баталгаажуулах зорилготой хяналтыг **Зөвлөх** бүхэлд нь, эсвэл хэсэгчилсэн байдлаар хийнэ.

Энэхүү дарааллаас гажсан, эсвэл түүнийг зөрчсөн тохиолдолд тухайн мөч хүртэл өч төчнөөн хөрөнгө мөнгө, цаг хугацаа, хүч хөдөлмөр зарцуулж хийсэн бүх ажлыг чанар, геометр хэмжээс, эзэлхүүн, тоо хэмжээний талаас нь хянах ба баталгаажуулах ямар ч боломжгүй болж, улмаар энэ асуудал утга учраа бүрмөсөн алдахын дээр үүнээс шалтгаалан тэдгээр нь хий дэмий, бараг хэрэггүй зүйл мэт үзэгдэх хэмжээнд хүрэх, ажлын хурдац саарч, тодорхойгүй хугацааны саатал үүсэх зэрэг туйлын ноцтой үр дагавар бий болдог юм.

Ийм учраас хяналтын дарааллын энэхүү амин чухал зарчмыг хэн ч хэзээ ч зөрчилгүй, ямагт чанд баримталж ажиллах ёстой шүү.

Жич: Аль нэг этгээдээс шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тухайн объектын зарим нэг үе шат, хийц хэсэгт жишээ нь хөндлөнгийн техникийн магадлал хийгдэж болох ч энэ нь талбайн хяналтаас тэс өөр асуудал юм.

1.5.2 Гүйцэтгэгч ба Зөвлөхийн харилцан итгэлцэл

Талбайн хяналт нь яг нарийндаа бол *Зөвлөх үйлчилгээ (ЗҮ)-ний* гэрээнд заасны дагуу Зөвлөх ба Гүйцэтгэгчийн харилцан итгэлцэл дээр үндэслэгдэн явагдах ёстой юм. Зөвлөхийн хяналт ба баталгаажуулалт нь Гүйцэтгэгчийн чадвар чадамж, дадлага туршлага, ажлыг гүйцэтгэж байгаа хандлага, арга хэлбэр, зохион байгуулалт, ерөнхий байр байдал зэргээр тодорхойлогдох итгэлцлийн дараах 3 түвшинд суурилан, мөн тэдгээрт хамаарах шалгалтын төрлөөр хийгддэг гэж ерөнхийдээ ойлгож болно.

I. Итгэлцэлийн түвшин хангалттай хэмжээнд байх.

Нөхцөл нь:

Гүйцэтгэгчийн туршлага ба чадамж хангалттай сайн, бүхий л төрлийн ажлаа ерөнхийдөө зохих ёсоор нь гүйцэтгэдэг, үйл ажиллагаагаараа үнэмшил төрүүлсэн, Зөвлөх түүнд бүрэн итгэж болох тохиолдолд,

а) Сонгон авч шалгах төрөл.

Гүйцэтгэгчээс ирүүлсэн АШХүсэлт тус бүрт хавсаргасан үр дүнгийн 10-30%-ийг Зөвлөх шалгахад болно.

II. Итгэлцэлийн түвшин доогуур байх.

Нөхцөл нь:

Гүйцэтгэгчийн туршлага ба чадамж дундаас доогуур, бүхий л ажлын ерөнхий явц, байдал ба гүйцэтгэл нь заримдаа зохих шаардлагыг хангадаггүй, арга ажиллагааны, улмаар чанарын зөрчил, гологдол гаргах нь олонтаа, ер нь үнэмшил төрүүлэх зүйл хомсдуу, Зөвлөх түүнд бүрэн итгэх үндэслэл бага тохиолдолд,

б) Хэсэгчлэн шалгах төрөл.

Гүйцэтгэгчээс ирүүлсэн АШХүсэлт тус бүрт хавсаргасан үр дүнгийн 75-85%-ийг шалгана.

III. Итгэлцэлийн түвшин маш муу байх.

Нөхцөл нь:

Гүйцэтгэгчийн туршлага ба чадамж муу, нийт үйл ажиллагаа нь ихэнхдээ шаардлагын дагуу явагддаггүй тул маш эргэлзээтэй, зөрчил дутагдал

байнга гаргадаг, алдаа мадаг ихтэй, Зөвлөх түүнд итгэх үндэслэл туйлын бага тохиолдолд,

в) *Бүрэн шалгах төрөл.*

Гүйцэтгэгчээс ирүүлсэн АШХүсэлт тус бүрт хавсаргасан үр дүнг 100% шалгах хэрэгтэй.

Хэрэв Гүйцэтгэгч нь ажлаа зохих шаардлагын дагуу бүрэн, чанартай хийдэг, хяналтынхан зөвхөн баталгаажуулах үүднээс зарим зүйлийг нягтлан шалгадаг байвал хамгийн зөв бөгөөд хялбар арга зам (өөрөөр хэлбэл *сонгон авч шалгах төрөл*) юм. Гэвч харамсалтай нь ямагт тийм байж чаддаггүй, дор хаяж б) төрөлд ойртоё гэхэд л тал бүрээс нэлээд их хүчин чармайлт, сэтгэл зүтгэл, хүч хөдөлмөр шаардсан, урт хугацааны үйл ажиллагаа болно. Одоо манайд ихэнх тохиолдолд сүүлчийн в) төрөл давамгайлж байгаа бөгөөд энэ нь бас л асуудал дагуулсаар байгаа билээ.

Нөгөө талаас Зөвлөхийн буюу хяналтын байгууллагуудын ойлголт ба хандлага, зохион байгуулалт, хүчин чадал, ИТА-ны мэдлэг, туршлага, хангалт, чадвараас хамаараад хянавал зохих ажил ба үзүүлэлтийн хэдэн хувь нь бодитой бөгөөд зохих номоороо шалгагдаж байгаад дүгнэлт хийж, түүн дээрээ үндэслэн цаашид явуулах үйл ажиллагааныхаа арга тактикийг боловсруулж ажиллах шаардлагатайг анхаарах нь зүйтэй.

1.5.3 Тогтоосон хэмжээ ба давтамжийн тогтмол байдал

Гүйцэтгэгчийн дотоодын хяналт ба шалгалт нь авто зам, замын байгууламжийн төрөл бүрийн ажлын эзэлхүүн, талбай, геометр хэмжээс гм тогтоосон хэмжээг, түүнчлэн тухайн объектын Техникийн шаардлага (ТШ)-д нарийвчлан зааж тусгасан туршилт, шинжилгээний ба хяналтын давтамжийг ягштал баримтлан, тогтмол хийгддэг байх ёстой юм. Эдгээр хэмжээ ба давтамж нь холбогдох аргачлалын хамт түүний ЧУТ-нд тусгагдсан байх ёстой. Гүйцэтгэгчээс ирүүлж, хянуулсан ЧУТ-г үндэслэн Зөвлөх өөрийн чанарын удирдлагын тогтолцоог боловсруулан мөрдөх ёстой.

Дээрх гол ойлголтуудыг сайтар мэдэж, зөв хэрэглэж хэвшихтэй холбогдолтой бусад асуудлыг энэхүү номын зохих хэсгүүдээс уншиж судлах зүйтэй.